

“ХҮРД” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 04-р сарын 28-ны өдөр

Дугаар:21/01

Улаанбаатар хот.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал компанийн хурлын зааланд 2021.04.28-ны өдрийн 16.00 цагт эхлэв.

“Хүрд “ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын гишүүн Ж.Олонбаяр хурлын ирцийг бүртгэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн талаарх мэдээллийг гаргаж, хурлын тооллогын комиссын дарга О.Шинэхүүг танилцуулахыг урилаа.

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга О.Шинэхүүгийн танилцуулснаар:

Хуралд саналын эрх бүхий 135266 ширхэг хувьцаатайгаас саналын эрхтэй 126,125.0 ширхэг хувьцаа эзэмшдэг 6 хувь нийлүүлэгч хүрэлцэн ирснээр ирцийн хувь 93,24 % болж, Компанийн тухай хуулийн 69.1-д “Саналын эрхтэй хувьцааны 50-иас дээш хувийг эзэмшдэг хувь нийлүүлэгчид оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно” гэж заасныг бүрэн хангаж байна.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Бат-Эрдэнэ, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Б.Мөнхбат нарын 6 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурал даргалагч Б.Мөнхбат ээлжит хурлыг нээж үг хэлж, хурлын дэгийг танилцуулав.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дэг:

1. Хэлэлцэх асуудлын талаарх ТУЗ-ийн мэдээлэл, дүгнэлтийг танилцуулах /20 мин/
2. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсан асуулт, хариулт. /хүн бүр 5 мин/
3. Тоологын комисс санал өгөх журмыг танилцуулж, саналын хуудсаар санал авах
4. Санал хураалтын дүнг шийдвэр бүрээр гаргаж хуралд танилцуулна. /10 мин/
5. Санал хураалтын дүнг үндэслэн хурлаас гарах шийдвэрийг танилцуулах /5 мин/
6. Хурлыг хаах

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах

2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, 2021 оны удирдлагын зардлыг батлах

ТАНИЛЦУУЛСАН НЬ:

Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахдаа Компанийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах хорооны 2016 оны 244 дүгээр тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасан шаардлагын дагуу хурлын зарыг өдөр тутмын 2 тогтмол хэвлэл /Өдрийн сонин, Зууны мэдээ/, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг Улаанбаатар телевиз, Монголын үндэсний олон нийтийн радиогоор 15 хоногийн давтамжтайгаар 2 удаа тус тус зарлаж, Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллээ.

Компанийн 2020 оны санхүүгийн тайланг мөн өдөр тутмын хэвлэлд нийтэлж, Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүллээ.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайланг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлын тооцоотой та бүхэн компани дээр ирж урьд нь танилцсан, одоо ч та бүхэнд хэвлэж тараасан байгаа. Та бүхний санал бодлыг сонсьё.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Би барилгын байгууллагад олон жил ажилласан, барилга угсралтын ажлын зовлон, жаргалыг мэднэ. Барилгын салбар бол тийм ч амар ашиг олчих салбар биш. Өнөөдрийн байдлаар барилгын норм дүрэм, цалингийн тариф шинэчлэгдсэн ч урьд онуудад тендерт орж авсан ажил учраас шинэ тарифаар цалинжуулаагүй юм байна.

Барилгажилтын оргил үед 30-40 барилга ашиглалтад өгч байхад 1 төгрөгийн барилга угсралтын ажлыг 85 мөнгөөр хийдэг байлаа. Одоо өнөөдрийн байдлаар 95-97 мөнгөөр хийдэг болж. Дэлхий даяар халдварт цар тахал өвчин дэлгэрч, эдийн засаг хүндхэн байгаа энэ үед барилга угсралтын ажлаа хийсээр, ажилчдаа ажилтай, цалинтай байлгаж байгаа нь сайн үзүүлэлт юм. Томоохонт тендер, төсөл аваад 2-3 жил үргэлжлэхэд ашгаа тооцох ч хэцүү. Хүрд компани ХК болсон цагаас 20 гаруй жил ногдол ашиг хуваарилж ирсэн. 2020 онд хувьцаа эзэмшигч хүмүүсийн хөрөнгийг найдвартай барьж, ногдол ашиг хуваарилжээ.

Компанийн 2020 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд ТУЗ-ийн өгсөн дүгнэлттэй танилцлаа. 2020 онд бизнес төлөвлөгөөгөөр компани нийт 6,3 тэрбум

төгрөгийн ажил үйлчилгээ гүйцэтгэх ба үүнээс 5,78 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил гүйцэтгэж, 442,6 сая төгрөгийн ашигтай байхаар төлөвлөсөн ч нийт борлуулалт 8.0 тэрбум 694 сая төгрөг, ашиг 431.74 сая төгрөг байна. Барилга угсралтын ажлын ашиг 265.1 сая төгрөг, түрээсийн ашиг 74.02 сая төгрөг, бусад орлого 65.15 сая төгрөг, банкны хадгаламж, харилцахын хүүгийн ашиг 288.3 сая төгрөг байгаа нь цар тахал гарсан 2020 онд удирдлага, санхүү ашиг олох тал дээр сайн ажилласныг илтгэж байна.

Ногдол ашигт нэгж хувьцаанд 479 төгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Ногдол ашгийн хэмжээ урьд оныхоос бага зэрэг буурсан ч хувьцаа эзэмшигчийн хувьд баяртай байна.

Удирдлагын зардлыг төлөвлөснөөс 92.2 сая төгрөгөөр хэмнэсэн нь мөн л хөл хориотой холбоотой гадаад, дотоод томилолт байхгүйгээс хэмнэлт гарсан гэж ойлгож байна.

ТУЗ-ийн дүгнэлтээс харахад мэргэжилтэй ажилтнуудыг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд 6 удаагийн сургалтад 3,8 сая төгрөг зарцуулсан байна. Үүнээс ч ихийг зарж сургаж, шинэ техник технологи эзэмшүүлэх хэрэгтэй.

Бизнес төлөвлөгөөний борлуулалтын орлогын хэмжээ нэмэгдсэн ч ашгийн хэмжээ буурсан байна.

Ажилтнуудын дундаж цалин 20.0%-147800 төгрөгөөр өссөн байгаа нь энэ цаг үед хамгийн сайн үзүүлэлт гэж дүгнэж байна. Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ.

Орон сууцаа барьж ашиглалтанд оруулсан нь том амжилт юм.

“Хүрд-Нарлаг” ХХК-ийн Барилгачин сувилал ажиллаагүй нь мөн л цар тахал, хөл хорионоос болж жижиг бизнесийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой юм.

Төмөр хийцийн цех, бетон эдлэлийн цехийн бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилтнаар хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна. Бие даалгасан хязгаарлагдмал хариуцлагатай компани болгох тал дээр анхаарч ажиллах.

Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа мөн хэвийн явагдаж байгаа юм байна.

Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлантай холбогдуулж асууж тодруулах 2 зүйл байна. Үүнд:

1. Тайланд байгууллага хүмүүст өгөх өглөг оны эхэнд 1,532.5 сая төгрөг байсан бол тайлант хугацаанд 3,058.94 сая төгрөгөөр нэмэгдэж, 653.4 сая төгрөгөөр буурч, оны эцэст 3938.04 сая төгрөг болж өглөг 2,405.5 сая төгрөгөөр өссөн гэжээ. Өглөг ямар шалтгаанаар өссөн талаар асуумаар байна.

2. Дансанд сул байгаа мөнгөөр Засгийн газрын бонд худалдан авах, банкинд хадгалуулах замаар ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж байгаа юу?

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Үйл ажиллагааны тайлангийн талаар тайлбар өгье. Байгууллага хүмүүст өгөх өглөг өссөн. Энэ нь хүмүүсээс авсан орон сууцны урьдчилгаа мөнгө юм. Баянзүрх орон сууцыг 2020 оны 12-р сарын 10-нд улсын комисст хүлээлгэн өгч, улсын комиссын акт, бичиг баримт бүрдүүлсээр он дууссан тул 2020 оны борлуулалт, ашигт тооцоогүй яваа. Тийм болохоор орон сууц захиалсан хүмүүсийн мөнгө өглөг хэлбэрээр тусгагдсан байгаа юм.

Засгийн газрын бонд худалдан авах шаардлага, боломж өнөөдрийн байдлаар байхгүй байна. Бид Сэлбэ дэд төвийн дулааны станцын 16 тэрбум, Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтийн 8,4 тэрбум төгрөгийн ажил гүйцэтгэхэд гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргахад хүндрэлтэй байлаа. Том тендерт ороод үүнийг ойлголоо. Банкны хадгаламжийн хүү 16-18% байхад мөнгөн хөрөнгөө хийдэг байхад харьцангуй өндөр ашиг болж байлаа. Одоо 2-3 жил үргэлжлэх ажил дээр хөрөнгөө хадгаламж болгон барьцаалж, баталгаа гаргаж байна. Баталгаа гаргасны шимтгэлд 6% хүү төлж байгаа. Тиймээс дансанд бонд худалдаж авах сул мөнгө байхгүй.

Мөн Сэлбэ дэд станцын барилга угсралтын ажлын санхүүжилт улс орны эдийн засгийн байдлаас хамаарч 3-5 сараар хоцорч олгогдож байгаа нь компанийн санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж байна.

Барилга угсралтын ажлаас ашиг олох өнөөдрийн хувьд тун хэцүү, 3-4% ашиг л гарч байна. Бараа материалыг үйлдвэрээс шууд нийлүүлж байгаа тулдаа ийм ашиг гарч байна. Барилгын салбарын цалин 2009 оны үнэлгээгээр явж байгаад БХБ Сайд 2020 онд цалингийн тариф шинэчлэх тушаал гарч 2021 оны 01-р сарын 1-нээс мөрдөж эхэлсэн. Гэвч бидний хэрэгжүүлж буй төслүүд цалингийн хуучин тарифаар гэрээ хийгдсэн. Тиймээс ажилчдад нэмэгдэл зардал, компанийн ашгаасаа цалин болгож өгч байгаа.

Төмөр хийц, бетон эдлэл, Орон сууцны салбарыг тусад нь гаргана. Борлуулалтын 1,5 тэрбум төгрөгийн орлоготой компаниудын татварын 90%-ийг буцаан олгоно гэснийг мөрдөж ажиллана

1993 онд анх ногдол ашиг олгож байснаас хойш тасралтгүй 29 жил олгож байна. Компанийн тухай хуульд ногдол ашиг олгох 3 үзүүлэлт байдаг. ХК компанийн хувьд хэдэн хувьцаа байгаа нь сонин биш, нэгж хувьцаанд хэдэн төгрөг олгож байгаа нь сонин. Ногдол ашиг банкны хугацаагүй хадгаламжийн хэмжээнд байгаа. Цэвэр ашгийн 10% орчим гэсэн бодлого барьж байгаа.

Удирдлагын урамшууллын хувьд ТУЗ-ийн 9, удирдах албан тушаалын 6, нийт 15 хүнд 28,9 сая төгрөг олгосон. 1 хүнд 2 сая хүрэхгүй төгрөг оногдож байна.

Компанийн цэвэр ашгийн 3-5% -ийн удирдлагын урамшуулал олгодог журамтай. Гэхдээ 5% олгосон жил байхгүй. Энэ талаар компанийн тухай хуульд заасан байгаа.

. Бид цар тахал гарч, гадаад дотоод хөл хорио тавигдсан хүнд нөхцөлд үйлдвэрлэлээ тасралтгүй явуулахын тулд хөрөнгө, хүч бололцоогоо дайчлан ажиллаж байгаа гэдгийг ойлгоорой.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Бид үндсэн үйл ажиллагаа болох барилга угсралтын ажлаас 265,1 сая төгрөгийн ашиг олсон.

Барилга угсралтын ажил хийж, ашиглалтад оруулсны дараа тухайн барилгын ашгийг тооцдог, ажил удаан хугацаанд үргэлжилдэг, эрсдэл өндөртэй салбар гэдгийг ойлгоосой гэж бодож байна. Барилга угсралтын ажлын ашиг валютын ханш, материалын үнийн өсөлтөөс хамаардаг. Төсөл хэрэгжсэний дараа ашиг, алдагдлаа тооцож, нэмэгдэл мөнгө олгодог.

Манай компанийн удирдлага цомхон бүтэцтэй. Инженер техникийн ажилтнуудын цалин доод түвшинд хэвээр л байна. Компанийн стратегийн удирдлагын бүтцийг бэлтгэх, чанаржуулах, төлөвлөх шаардлагатай байна. Нэг санал хэлье. Алс хэтийн удирдлагыг авч явах хүмүүсээ сургах, томилох талаар анхаарах

-Хүний нөөцийн асуудалд анхаарах, сургах, төлөвлөх шаардлагатай.

Хувьцаа эзэмшигч Ц.Эрдэнэсүх: Ашиглалтанд оруулсан орон сууцны борлуулалт хэдэн хувьтай байна? Баянзүрх орон сууцны нийт өртөг хэдэн төгрөг байгаа вэ? Ашиг хэдэн хувьтай байна?

Хувьцаа эзэмшигч Б.Энхжаргал: Баянзүрх орон сууцыг 3 жил барьж ашиглалтанд орууллаа. Орон сууцны борлуулалт 70%-тай байна. Нийт 8 тэрбум төгрөг зарцуулаад байна. Урьдчилсан байдлаар 2021-2023 онд 4-4,5 тэрбум төгрөгийн ашиг олно гэж тооцож байгаа. Тэгэхдээ орон сууцны борлуулалт, ипотекийн зээлээс хамаарна.

Хувьцаа эзэмшигч Б.Мөнхбат: Мэдээллийн чанартай зүйл байна. Хувьцаа эзэмшигч Г.Алтансүх Санхүүгийн зохицуулах хороогоор дамжуулан ТУЗ-д 3 асуулт ирүүлсэн байна.

Г.Алтансүх хөл хорионы улмаас хуралд оролцсонгүй. Г.Алтансүхийн асуулгад бичгээр хариу өгч байгааг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хувьд хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулья. Үүнд:

1. Төв аймаг. Лүн сум. Шандын ам гэх алтны шороон ордын ашигт малтмалын ашиглалтын лиценз худалдсан талаар:
ЛМО Майнинг ХХК энэхүү шорооны ордын талбайг Хүрд ХК-тай хамтран ашиглах нөхцөлтэйгээр шилжүүлсэн юм. Гэвч Шандын аманд ус байхгүй, цахилгааны шугам холоос татах, усыг Туул голоос зөөвөрлөж угаахад байгаль орчны талаас зөвшөөрөхгүй, ашиглалтын зардал өндөр гэсэн шалтгаанаар Хүрд ХК хөрөнгө гаргах боломжгүй гэсний улмаас лицензийг ЛМО Майнинг ХХК-д буцаан шилжүүлсэн. Хүрд ХК-д лиценз шилжүүлэн өгөх, буцаан авах явцад ямар нэгэн төлбөр тооцооны асуудал үүсээгүй болно. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2013 оны 04-р сарын 25-ны өдрийн хуралд энэ талаар таны асуултад “Энэ ордны эзэмшигч нь манай компани биш” гэж хариулт өгч байсан. /Лиценз эзэмшигчийн тайлбарыг хавсаргасан байгаа./

2. Компанийн барьж ашиглалтанд оруулсан орон сууцанд нийт 8,0 тэрбум төгрөг зарцуулсан тооцоо гарч байгаа. Уг орон сууцыг компанийн өөрийн хөрөнгөөр барьсан бөгөөд ямар нэгэн гаднын хөрөнгө оруулалт байхгүй болно. Орон сууцыг 2020 оны 12-р сарын 10-нд улсын комисст хүлээлгэн өгсөн, одоогоор борлуулалт 70 орчим хувьтай байгаа тул 2020 онд ашиг тооцогдоогүй байгаа. Борлуулалтын ашиг 2021-2023 онд тооцогдоно. Урьдчилсан байдлаар 4,0-4,5 тэрбум төгрөгийн ашиг олно гэж тооцож байгаа.
3. Хүрд ХК-ийн хэрэгжүүлж байгаа төсөлд туслан гүйцэтгэгчээр орж байгаа компаниуд нь мэргэжлийн байгууллагууд бөгөөд тухайн ажил дээр гэрээ байгуулан ажилладаг, ашиг сонирхлын зөрчилгүй болно. Туслан гүйцэтгэгч нарын байгуулсан гэрээ, гүйцэтгэсэн ажил, олгосон санхүүжилт жил бүр санхүү, татварын шалгалтад хамрагддаг бөгөөд одоогоор ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

Энэ албан бичгийг бид Санхүүгийн зохицуулах хороогоор дамжуулан хүргүүлэх болно.

Өөр асууж тодруулах зүйлгүй бол саналаа хураах уу?

Хувьцаа эзэмшигч Д.Дашдорж: Компанийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Б.Бат-Эрдэнэ: Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлахад татгалзах зүйлгүй.

Хувьцаа эзэмшигчдийн санал шүүмжлэлийг сонссоны дараа компанийн 2020 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах санал хураалт явагдав.

Тооллогын комиссын дарга О.Шинэхүү санал хураалтын дүнд үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар.

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,125.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны **0** ширхэг хувьцаа буюу **0** %

2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны **126,125.0** ширхэг хувьцаа буюу **100,0** %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

3. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, 2021 оны удирдлагын зардлыг батлах асуудлаар:

Зөвшөөрсөн: Нийт саналын эрхтэй хувьцааны 126,125.0 ширхэг хувьцаа буюу 100,0 %.

Татгалзсан: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

Түдгэлзсэн: Саналын эрхтэй хувьцааны 0 ширхэг хувьцаа буюу 0%

ХУРЛЫН ШИЙДВЭР:

Хурлын дарга Б.Мөнхбат: Тооллогын комиссын шийдвэрийг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлав.
3. Компанийн 2021 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлав.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.20 цагт хурал дуусав.

ПРОТОКОЛ ХЯНАВАН:

ХУРЛЫН ДАРГА

Б.МӨНХБАТ

ПРОТОКОЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ГАНТУЯА